

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН СУДАЛГАА

Н.Хүсэл

ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн багш

Khusel.N

Хураангуй: Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомстлоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж заасан байдаг.

Иймээс гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс болохын хувьд хууль тогтоомжийн хүрээнд хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах талаар хэрхэн тусгасан байдал, салбар хоорондын ажлын уялдаа, зохицуулалтыг хангах, холбогдох талуудын хариуцлага, эрх, үүргийг хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн уялдаа, эрх зүйн зохицуулалтыг судалж үзлээ.

Товч үг. Эрх зүй, орчин, аюул, байгалийн тэнцэл, нөхөн сэргээх

Оршил: Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол Улсын “оршин тогтнохуйн аюулгүй байдал”, “эдийн засгийн аюулгүй байдал”, “дотоод аюулгүй байдал”, “хүний аюулгүй байдал”, “хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”, “мэдээллийн аюулгүй байдал” харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна.”, мөн хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал нь байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомсдолоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн гэж заасан байдаг.


Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгийн нэг болох “Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”-ын асуудал өнөөдөр олон улсын болон үндэсний хэмжээний зайлшгүй судлах асуудлын нэг болоод байна. Тухайлбал, Олон Улсад Даян дэлхийн тогтвортой хөгжил-2030, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030 баримт бичгүүдэд мөн үндэсний хэмжээнд “Тогтвортой хөгжлийн зорилго-2030”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ гэж

заасан байна.

Байгалийн болон техникийн гаралтай гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, төрийн төв болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх, хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг, алба хаагчдын эрх зүйн байдал, санхүү төсөвтэй холбоотой харилцааг зохицуулах талаар Монгол Улсын 60 гаруй хуулийн 125 зүйлийн 157 заалтыг тусгаж өгсөн байна.⁴⁵

Дээрхтэй холбогдуулан Монгол Улсын хэмжээнд “Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”-ыг тусгасан эрх зүйн зохицуулалтын асуудлыг нарийвчлан авч үзэж Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан зүйл, заалт хэсгийг бүх нийтээрээ дагаж мөрддөг эсэх, тухайн холбоотой хуульд нэмэлт тодотгол хийх шаардлагатай эсэхийг судлахаар зорилоо.

Зураг 1. Үндэсний аюулгүй байдал ба Монгол улсын хуулиудад тусгагдсан гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой заалтуудын хамаарал (эзлэх хувиар):



Оршин тогтнохын аюулгүй байдал болон Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд хамааралтай хуулийн заалтууд нь нийт хуулийн заалтуудын 50 хувийг эзэлж байгаа бол амьдрах орчны аюулгүй байдал болон хүний аюулгүй байдалтай хамааралтай хуулийн заалт нь 10-13 гаруй хувийг эзэлж байна. (Зураг 1)

⁴⁵ Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал судалгааны ажил УБ., 2020 он

Хүснэгт 1. Монгол Улсын хууль эрх зүйн зохицуулалтад хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах заалтуудын хамаарал:

Хууль эрх зүй	Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангахтай холбоотой заалтууд
Монгол Улсын Үндсэн Хууль (1992он)	Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” Гучин наймдугаар зүйл. 4/хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;
Байгаль Орчныг Хамгаалах Тухай хууль (1995)	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн тавдугаар зүйлийн 1 дахь хэсэгт “Төр нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлнэ.”
Гамшгаас Хамгаалах Тухай хууль (2017)	4.1.19."гамшгийн онцгой нөхцөл байдал" гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг; 4.1.24."бэлэн байдал" гэж гамшиг, аюулын сөрөг үр дагаврыг урьдчилан тооцож, хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтын цогц арга хэмжээг.
Барилгын Тухай хууль (2016)	Барилгын тухай хуулийн арван нэгдүгээр зүйлийн 11.1.1.механик аюулгүй байдлыг хангах: барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь барилгын ажлын болон ашиглалтын үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой байх; 11.1.3.хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах: барилга байгууламж хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр төлөвлөгдөн баригдаж, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө болон амьтан, ургамалд аюул учруулахгүй байх; Арван хоёрдугаар зүйлийн 12.1.3.барилга байгууламжаас хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэх дуу чимээ, доргио, утаа, хорт хий, өндөр үелзлэл, хог хаягдал, цацраг идэвхт бодис, хөрсний бохирдол зэргээс хамгаалагдсан байх; 12.1.4.нийтийн эзэмшлийн гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг орон зайг чөлөөтэй ашиглах, авто зогсоол түүний орц гарцыг хөдөлгөөнд саадгүй байхаар төлөвлөсөн байх;

	12.1.5.хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг техникийн болон галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн, гамшиг, аюулт үзэгдлийн үед нүүлгэн шилжүүлэх нөхцөлийг хангасан байх;
	Шүүх Шинжилгээний Тухай хуулийн нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шүүх шинжилгээ хийх, хүрээлэн байгаа орчны хохирлыг тооцох, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох, шүүх шинжилгээ хийх үндэслэл, журам болон шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Гуравдугаар зүйлийн 3.2.Шүүх шинжилгээний байгууллага эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ тооцох болон гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтооход энэ хууль үйлчилнэ. Арван хоёрдугаар зүйлийн 12.4.1.галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, тэдгээрийн хэрэгсэл, протехникийн хэрэгсэл, цацраг идэвхт үүсгүүр, хими, биологийн хорт бодис зэрэг хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх объект; Гучин наймдугаар зүйлийн 38.1.Шинжилгээний байгууллага энэ хуульд зааснаас бусад тохиолдолд эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дараах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд шинжилгээ хийлгэх шийдвэрээр хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн тус бүрээр хийнэ: 38.1.1.иргэн, хуулийн этгээдийн хууль бус үйл ажиллагааны улмаас хүрээлэн байгаа орчинд хохирол учирсан; 38.1.3.байгаль орчны нөлөөллийн ерөнхий, эсхүл нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж байгаа, эсхүл учруулсан. 38.2.Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг шинжээчдийн баг хийнэ. 38.3.Шинжилгээний байгууллага хүрээлэн байгаа орчны хохирлыг хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн тус бүрээр нь тооцохдоо нөхөн сэргээх зардлыг давхар тооцно. 38.4.Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг хийхдээ энэ хуульд заасан шинжилгээний нийтлэг журмыг баримтлан байгаль орчны хууль тогтоомж, түүнийг дагаж гарсан эрх зүйн актыг дагаж мөрдөнө. 38.5.2.байгаль орчны нөлөөллийн ерөнхий, эсхүл нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа

Шүүх Шинжилгээний Тухай хууль (2022)	орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол ерөнхий үнэлгээний дүгнэлт, эсхүл нарийвчилсан үнэлгээний дүгнэлт үнэн зөв хийгдсэн эсэхийг тогтоолгох; 38.5.3.хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээний тайлан, дүгнэлт нь эргэлзээтэй бол байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, эсхүл нарийвчилсан үнэлгээний дүгнэлт үнэн зөв хийгдсэн эсэхийг тогтоолгох; 38.5.4.хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээний тайлан, дүгнэлт эргэлзээтэй бол уг тайлан, дүгнэлт нь үнэн зөв хийгдсэн эсэхийг тогтоолгох. 38.6.Хүрээлэн байгаа орчинд хохирол учруулсан шинжилгээний материал нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн байгууллагын тайлан, дүгнэлт гарсан, эсхүл хянан магадалгаа хийгдсэн байна. 38.7.Шинжилгээний байгууллага шаардлагатай тохиолдолд хүрээлэн байгаа орчны шинжилгээний объектыг мэргэжлийн байгууллагын лабораторид илгээж, гарсан үр дүнг үнэлэн дүгнэлт гаргаж болно. 38.10.Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. Тайлбар: -Энэ хуулийн 38.1-д заасан хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн хэсэг гэж агаар, ус, хөрс, газар, түүний хэвлий, амьтан, ургамал, ойг ойлгоно.
Цөмийн Энергийн Тухай хууль (2009)	Арван нэгдүгээр зүйлийн 11¹.1.8.хүрээлэн байгаа орчны болон ахуйн хэрэглээний бараа, материал, хүнсний бүтээгдэхүүн, ундны ус, барилгын материалын цацрагийн түвшний хяналт шинжилгээ хийх, тэдгээр нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг тогтоох ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх, чанарын баталгаажилтыг хангах арга хэмжээ авах; Хорин наймдугаар зүйлийн 28.10.Энэ хуулийн 28.9-д заасан мөнгөн хөрөнгийн хэмжээг нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох эрсдлийг харгалзан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран гаргасан саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.
Стандартчилал, Техникийн Зохицуулалт,	Тавдугаар зүйлийн 5.1.Техникийн зохицуулалтын зорилго нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад оршино. Арван гуравдугаар зүйлийн 13.2.Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг

Тохирлын Үнэлгээний Итгэмжлэлийн Тухай хууль (2017)	сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулна. Хорин долдугаар зүйлийн 27.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын боловсруулсан стандартын төсөл нь хууль тогтоомж, техникийн зохицуулалт болон үйлдвэрлэгч, хэрэглэгчийн эрх ашигт харшлаагүй, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулахааргүй байна.
Төмөр Замын Тээврийн Тухай хууль (2007)	Арван долдугаар зүйлийн 17.2.Хууль тогтоомж, үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн эрх ашигт харшлахгүй, үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулахгүй бол төрийн захиргааны төв байгууллага нь олон улс, гадаад улсын дэвшилттэй стандартыг эрх бүхий байгууллагад бүртгүүлснээр хэрэглэж болно. Хорин дөрөвдүгээр зүйлийн 24.1.5.хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх.
Зөрчлийн Тухай хууль (2017)	6.17 дугаар зүйл. 6.Импортлох түүхий эд, бараа, бүтээгдэхүүн, бодис, бэлдмэл, техник, технологи нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан тухай эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 9.7 дугаар зүйл. 2.Соёлын өвийн судалгаа, шинжилгээ хийхдээ язгуур шинж, унаган төрх байдал, хүрээлэн байгаа орчны зохиомжийг эвдэж хуулиар тогтоосон журам, эсхүл стандартыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 10.4.малтлага, судалгааны явцад үүссэн нүх, хонхор болон хүрээлэн байгаа орчны үзэмжийг эвдсэн элс, шороо, чулуун овоолго үлдээсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 10.2 дугаар зүйл. 5.Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн зах зээлд нийлүүлж байгаа бараа, ажил, үйлчилгээ нь хэрэглэгчийн амь нас, эрүүл мэнд болон хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулсан, эсхүл заавал мөрдөх стандартын болон техникийн зохицуулалтын шаардлагыг хангаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг есөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг есөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

	10.7 дугаар зүйл. 4.3.барааны чанарын доголдол, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюултай шинж чанарыг нуун дарагдуулах; 10.25 дугаар зүйл. 6.Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл эхэлснээс хойш гурван сарын дотор тохирлын баталгаанд хамруулаагүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
Зөвшөөрлийн Тухай хууль (2022)	2.1 дүгээр зүйл. 2.Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, санхүүгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүй үйл ажиллагаа, эсхүл тусгай болзол, шаардлагыг хангасны үндсэн дээр хэрэгжүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа, эсхүл ашиг олох зорилгоор болон үйлдвэрлэлийн зориулалтаар байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахад тусгай зөвшөөрөл олгоно. 6.2 дугаар зүйл. 1.3.зөвшөөрөл эзэмшигч нийтийн эрх ашиг, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчин, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлсэн, их хэмжээний хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон зөвшөөрлийг хүчингүй болгоно. 9.3 дугаар зүйл. 2.1.хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хамгаалахад тухайн шинээр бий болгох зөвшөөрөл шаардлагатай эсэхэд дүгнэлт гаргана.
Төмөр Замын Тээврийн Тухай хууль (2024.01.01)	4 дүгээр зүйл. 4.1.14."аюултай ачаа" гэж төмөр замын тээвэрлэлт, ачилт, буулгалт, хадгалалтын явцад хүний эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчинд хор хөнөөл учруулах, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжид эвдрэл, гэмтэл үүсгэх, улмаар тэсэрч, дэлбэрэх, шатах шинж чанартай, үхэл, хордлого, түлэгдэлт, өвчин, осол үүсгэж болзошгүй химийн бодис, бүтээгдэхүүн, эд зүйлсийг; 4.1.20."төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдах" гэж төмөр замын технологийн горим зөрчигдсөнөөс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, хүн, хуулийн этгээдийн өмчид хохирол учруулах осол, зөрчлийг; 18 дугаар зүйл. 18.1.Төмөр замын суурь бүтцийг гадны сөрөг хүчин зүйл, болзошгүй эрсдэлээс сэргийлэх, төмөр замын тээврийн аюулгүй байдал алдагдах, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхээс хамгаалах зориулалт бүхий хэсэгчилсэн хамгаалалтын бүстэй байж болно. 42 дугаар зүйл.Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах 42.6.5.хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр ажиллах.

Төрийн Хяналт Шалгалтын Тухай Хууль (2003)	5 дугаар зүйл. 5.3.Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар ноцтой аюул болон их хэмжээний хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналт шалгалтыг хяналт шалгалтын байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр энэ хуулийн 5.2-т заасан удирдамжгүйгээр хийж болно. 5².1.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр, түүнчлэн осол аваар, халдварт өвчин, хордлого зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр хийнэ. 5⁵.1.Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, нийгмийн аюулгүй байдалд учруулж болох хор хохирол, үр дагаврыг харгалзан хяналт шалгалтын объектын эрсдэлийг бага, дунд, их хэмжээний гэж ангилна. 10 дугаар зүйл. 10.9.7.хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох, шаардлагатай зүйлийг ариутгах, хоргүйжүүлж цэвэршүүлэх, тухайн барилга байгууламж, машин, тоног төхөөрөмжийн ашиглалтыг зогсоох, холбогдох бүтээгдэхүүнийг худалдах, борлуулахыг хориглох, устгах буюу зохих шаардлагад харшлахгүй бол өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухай олон нийтэд зарлан мэдээлэх.
Монгол Улсын Нийслэл Улаанбаатар Хотын Эрх Зүйн Байдлын Тухай хууль (2021)	49 дүгээр зүйл. 49.1.Нийслэл хотын хөгжлийн түүх, хэтийн төлөв, хотжилт, хот байгуулалт, хүн ам, хүрээлэн байгаа орчны талаар тулгамдаж байгаа асуудлыг судлах чиг үүрэг бүхий судалгаа, шинжилгээний төв нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн дэргэд ажиллана.
Соёлын Өвийг Хамгаалах Тухай хууль (2014)	28 дугаар зүйл. 28.1.4.малтлага, судалгааны явцад үүссэн нүх, хонхор болон хүрээлэн байгаа орчны үзэмжийг эвдсэн элс, шороо, чулуун овоолго үлдээхийг хориглоно.
Эрүүгийн Хууль (2015)	23.6 дугаар зүйл. 1.Эрх бүхий мөрдөн шалгах байгууллагын ажилтан, албан тушаалтан хүний амь бие, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хуулиар хориглосон аюултай тусгай техник хэрэгсэл ашигласан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хот Байгуулалтын Тухай (2008)	3 дугаар зүйл. 3.1.1."хот байгуулалт" гэж түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах, барьж байгуулах, иж бүрэн тохижуулах цогцолбор үйл ажиллагааг; 3.1.7."хот байгуулалтын кадастр" гэж нутаг дэвсгэрийн ашиглалт, хүрээлэн буй орчны төлөв байдал, инженерийн шугам сүлжээний хангамжийн түвшин, барилга байгууламж, хүн амын амьдрах орчны чанарын тухай байр зүйн зураглал, мэдээллийн нэгдмэл санг;
Усан Замын Тээврийн Тухай Хууль (2017)	11 дүгээр зүйл. 11.2.Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
Дотоодын Цэргийн Тухай (2017)	28 дугаар зүйл. 28.1.8.хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор уршиг учруулж болзошгүй болон учруулж байгаа амьтныг галт зэвсэг ашиглан устгах
Органик Хүнсний Тухай (2016)	5 дугаар зүйл 5.1.4.хүрээлэн байгаа орчин, одоо болон ирээдүй хойч үеийн эрүүл мэнд, сайн сайхныг хамгаалах, бүтээгдэхүүний органик болон байгалийн шинж байдлыг хадгалахад чиглэсэн хариуцлагатай арга технологиор үйлдвэрлэл эрхлэх. 7 дугаар зүйл. 7.1.2.мал, амьтан, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний байгалийн шинж чанарыг хадгалах үйлдвэрлэлийн арга технологи боловсруулж мөрдөх;
Автотээврийн Тухай Хууль (1999)	9 дүгээр зүйл.9.2.Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
Хог Хаягдлын Тухай Хууль (2017)	34 дүгээр зүйл. 34.9.4.судалгаа, шинжилгээ, сургалтын явцад үүссэн, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөлөл нь тогтоогдоогүй шинэ, эсвэл шинж чанар нь судлагдаагүй химийн бодисын хаягдал;
Засгийн Газрын Тусгай Сангийн Тухай Хууль (2019)	7 дугаар зүйл. 7.2.4.хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлого; 7.3.3.хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

	7.3.5.хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгахад шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардлыг санхүүжүүлэх; 11 дүгээр зүйл. 11.5.3.алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирсан хохирлыг арилгах;
Ашигт Малтмалын Тухай Хууль (2006)	38 дугаар зүйл. 38.1.2 энэ хуулийн 38.1.1-д заасан төлөвлөгөөнд хүрээлэн байгаа орчны бохирдолтыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, эвдэгдсэн газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болох нөхөн сэргээх арга хэмжээг тусгах;
Орон Сууцны Тухай Хууль (1999)	9 дүгээр зүйл 9.4.3.хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө, үр дагавар гаргуулахгүй байх.
Монгол Улсын Засгийн Газрын Тухай Хууль (1993)	11 дүгээр зүйл.Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаархи Засгийн газрын бүрэн эрх 2.Байгалийн баялгийг судалж нөөцийн хэмжээ, эдийн засгийн нэгдсэн үнэлгээг тогтоох, хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчны тэнцвэрт байдал болон үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжлийн шүтэлцээг хангах нэгдсэн арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.
Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын Тухай Хууль (2020)	72 дугаар зүйл 72.1.5.эдийн засаг, нийгмийн хөгжил, хот байгуулалт, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, төрөөс хүн амд үзүүлэх үйлчилгээтэй холбогдсон асуудлаар яам, агентлагт санал тавьж шийдвэрлүүлэх. 76 дугаар зүйл. 76.2.Үндэсний болон бүс нутаг, олон улсын эдийн засаг, байгалийн тэнцэл, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөө зэрэг нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тодорхой онцлогийг илэрхийлэх нөхцөл болно.
Зөрчил Шалган Шийдвэрлэх Тухай Хууль (2017)	5.3 дугаар зүйл 1.Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд, эсхүл шууд бусаар хор хохирол учруулж байгаа, эсхүл учруулж болох нөхцөл байдал үүссэн үед холбогдогчийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн, эсхүл барилга байгууламж, машин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг прокурорын зөвшөөрлөөр түр зогсооно.

Хүснэгт 2. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангахтай холбоотой удирдлагын баримт бичгүүд:

Бодлогын баримт бичиг	Үндэсний аюулгүй байдлын хангахтай холбоотой заалтууд
--------------------------	---

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010 он)	3.5 Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомстлоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн. 3.5.5.1. Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авна. 3.5.5.2. Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, чадавхыг бэхжүүлнэ. 3.5.5.3. Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологи нэвтрүүлэх, хяналт-шинжилгээний сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах техник хэрэгсэл, хүний нөөцийг системтэйгээр бэлтгэж, мэдээллийг хэрэглэгчид шуурхай хүргэх арга замыг боловсронгуй болгон эртнээс сэрэмжлүүлэх чадавхыг бүрдүүлнэ. 3.4 Хүний аюулгүй байдал 3.4.1.11. “ Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай эмнэлгийн тусламжийг хүн амд шуурхай хүргэх чадавхыг байнга дээшлүүлнэ” 3.4.2.3. “...Гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана”. 3.4.3.1 “Иргэдийн амьдрах, ажиллах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний аюулгүй байдлыг баталгаажуулах чухал үндэс болно”.
Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (2016 он)	2.1.5.Дэд бүтцийн салбар Зорилт 6. Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ. 2.3.2.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох

	Зорилт 1.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ
Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр(2011он)	Улсын Их Хурлын 2011 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 22 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг тус тус баталсан. Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилго нь гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх, гамшгийн эмзэг байдлыг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавх, бэлэн байдлыг дээшлүүлэхэд оршино. Энэхүү хөтөлбөр нь 2011-2015 он, 2015-2020 он гэсэн 2 үе шаттай хэрэгжиж байна. Эхний үе шатны хэрэгжилтийн тайланг 2016 онд гаргасан.
Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой Бууруулах үндэсний хөтөлбөр (2015)	Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолын хавсралт. Хөтөлбөрийн зорилго нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаанд иргэдийг оролцуулан, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, аюулгүй амьдрах ухамсарт соёл болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулахад оршино.
Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2017он)	Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолын хавсралт. Гамшгийн аюул, өртөнгө, эмзэг байдлыг бууруулах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулж, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэхэд энэхүү стратегийн зорилго оршино.
Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр (2016 он)	Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралт.4.3.3.Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эртнээс сэрэмжлүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, бүх нийтийн оролцоог сайжруулан, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ.
Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 Оны Үйл Ажиллагааны Хөтөлбөр (2020 24 дугаар тогтоол)	4.3.16.Бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, хүрээлэн байгаа орчны эрүүл, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хэмжил зүйн эталоныг хөгжүүлнэ. Ногоон хөгжил 5.1.Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи

	нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020 23 дугаар тогтоол)	Зургаа.Ногоон Хөгжил Зорилго 6.Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.
"Алсын Хараа-2050" Монгол Улсын Урт Хугацааны Хөгжлийн Бодлого (2020 52 дугаар тогтоол)	Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн I үе шат (2021-2030): Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үе. Зорилт 6.1. 1.Хүрээлэн байгаа орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. Зорилго 7.Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана. Зорилт 8.2. 4.Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, бүс, орон нутгийн хүн амын тоонд үндэслэн төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний стандарт, нормативын шаардлагыг үе шаттайгаар хангаж, иргэдийн эрүүл, аюулгүй, таатай ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлсэн байна. Зорилт 9.2.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.
"Шинэ Сэргэлтийн Бодлого"-ыг Хэрэгжүүлэх Эхний Үе Шатны Үйл Ажиллагааны Хөтөлбөр (МУИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол)	Зорилт 5.4. 5.4.1 Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор байгаль орчны хяналт, шинжилгээ, үнэлгээг боловсронгуй болгон хэрэгжүүлэх Ковид-19 цар тахлын улмаас эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд тодорхой хугацаанд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийхгүй бөгөөд зөвхөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллээр болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийнэ. Ингэснээр төрийн хүнд суртлыг багасгах, бизнес эрхлэгчид зардал, цаг хугацааг хэмнэсэн байна.
Монгол Улсын Их Хурлын Тогтоол (2019)	б/ашигт малтмал хайх, ашиглах явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх стандартын дагуу хүний аюулгүй байдал болон хүрээлэн байгаа орчинд үзүүлдэг сөрөг нөлөөллийг багасгаж, уул уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн ажлыг олон улсын жишигт нийцүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
Засгийн газрын 2019 оны 106 дугаар тогтоолын хавсралт	3.1.5. байгалийн нөөц, баялаг, материал, түүхий эд, түлш эрчим хүч, хөдөлмөрийн нөөцийг зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй, хамгаалах; 3.1.8. физик, хими, биологи, цацраг, өндөр хэлбэлзлийн долгионы болон бусад хортой бодисын нөлөөллөөс иргэд, хүрээлэн байгаа орчин хамгаалагдсан байх;

	-Барилгын ажлын зохион байгуулалт, технологийн бэлтгэл, барилгын ажлын ерөнхий дүрэм, барилгын ажлын механикжуулалт, хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангах ба барилгын ажлын явцад хүрээлэн буй орчныг хамгаалах;
Бичил Уурхайгаар Ашигт Малтмал олборлох журам (Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоол)	2.1.8.хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа үйл ажиллагааг зогсоох; 10.2.2.хүрээлэн буй орчны бохирдол доройтлыг бууруулах, байгалийн баялгийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;
Удаан Задардаг Органик Бохирдуулагчийн Тухай Стокгольмын Конвенц	Нэгдүгээр зүйлийн Хүрээлэн буй орчин, хөгжлийн тухай Риогийн Тунхаглалын 15 дугаар Зарчимд тусгасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах аргачлалыг харгалзан энэхүү Конвенцийн зорилго нь хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг удаан задардаг органик бохирдуулагчаас хамгаалахад оршино. Гуравдугаар зүйлийн а.гарц хаягдлаас сэргийлэх буюу түүнийг хамгийн бага хэмжээнд нь хүртэл бууруулахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авч, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалах: в)Хавсралт А-д дурдсан бөгөөд үйлдвэрлэл, хэрэглээний талаарх тусгай нөхцөл нь ямар ч Талд үйлчлэхээ больсон химийн бодисыг 6 дугаар зүйлийн 1 (г)-д заасанчлан хүрээлэн буй орчинд халгүйгээр зайлуулахаас бусад нөхцөлд экспортлохгүй байх; 6.Хавсралт А-гийн дагуу тусгай зөвшөөрөл авсан буюу Хавсралт Б-гийн дагуу тусгай зөвшөөрөл авсан буюу зориулалт нь зөвшөөрөгдсөн аливаа Тал тусгай зөвшөөрөл, зориулалтын дагуу явагдаж буй үйлдвэрлэл, хэрэглээ хүнд нөлөөлөх, хүрээлэн буй орчинд хаягдал болон гарахаас сэргийлэх буюу тийм нөлөө, хаягдлыг хамгийн бага байлгах аргаар үйл ажиллагаагаа явуулна. Зөвшөөрөгдсөн хэрэглээ, зориулалтын улмаас хүрээлэн буй орчинд хэвийн нөхцөлд зайлшгүй гарах гарц хаягдлыг мөрдөгдөж байгаа стандарт, зөвлөмжийн дагуу аль болох бага хэмжээнд байлгана.

Дээрх хууль, бодлогын баримт бичигт хийсэн шинжилгээнээс дүгнэн үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тунхагласан. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.5.5.2-т “Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж, эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж төв, орон нутгийн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чадавхыг бэхжүүлнэ” гэж заасан байна.

Дүгнэлт

Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын талаар тусгасан 24 хуулийг авч үзэхэд хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах болон хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх талаар тусгасан байна. Мөн холбогдох бодлогын баримт бичиг дүрмүүдийг судалж үзэхэд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “байгаль орчны тэнцвэрийг хадгалж, усны нөөцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, биологийн олон янз байдлын хомстлоос сэргийлэх, орчны бохирдол, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн.”, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ”, “Алсын Хараа-2050” Монгол Улсын Урт Хугацааны Хөгжлийн Бодлогод “Хүрээлэн байгаа орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. Улсын батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, бүс, орон нутгийн хүн амын тоонд үндэслэн төрөөс үзүүлэх нийгмийн үйлчилгээний стандарт, нормативын шаардлагыг үе шаттайгаар хангаж, иргэдийн эрүүл, аюулгүй, таатай ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлсэн байна. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.” зэрэг хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан зааж өгсөн байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрх бүхий субъектүүдийн бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах үндэсний болон орон нутгийн зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний эрх, үүргийн зохицуулалтыг шинэчлэн тусгаснаас гадна гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг тодорхойлон томьёолсон.

Мөн хуульдаа төрийн болон нутгийн захиргааны байгууллага тухайн жилд батлагдсан төсвийн 1.0 хувийг, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд

төлөвлөж зарцуулах, аймаг, нийслэл, сум дүүрэг нь тухайн жилийн батлагдсан төсвийн 1.0 хувийг орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах санд тусгаж, гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулна хэмээн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг тодорхой болгосон.

Энэхүү нөхцөл байдалд одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хүрээнд гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалт, салбар хоорондын ажлын уялдаа, зохицуулалтыг хангах, холбогдох талуудын хариуцлага, эрх, үүргийг хэрэгжүүлэх, хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, иргэний хууль ёсны эрхийг түр хязгаарлах, үнэн зөв мэдээ мэдээллийг нэгдсэн байдлаар хүргэх зэрэг шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд холбогдох хууль тогтоомжийн уялдаа, эрх зүйн зохицуулалтын чадамж бүрэн дүүрэн хангагдаагүйгээс хүндрэл үүсэж байсныг бас бид эргэн харах хэрэгтэй байна гэж үзлээ.

Ашигласан материал

Хууль, тогтоомж:

- 1.Монгол Улсын Үндсэн Хууль (1992он)
- 2.Байгаль Орчныг Хамгаалах Тухай хууль (1995)
- 3.Гамшгаас хамгаалах тухай хууль
- 4.Барилгын Тухай хууль (2016)
- 5.Шүүх Шинжилгээний Тухай хууль (2022)
- 6.Цөмийн Энергийн Тухай хууль (2009)
- 7.Стандартчилал, Техникийн Зохицуулалт, Тохирлын Үнэлгээний Итгэмжлэлийн Тухай хууль (2017)
- 8.**Удаан Задардаг Органик Бохирдуулагчийн тухай Стокгольмын Конвенц**
- 9.Төмөр Замын Тээврийн Тухай хууль (2007)
10. Монгол Улсын Их Хурлын Тогтоол (2019)
11. Зөрчлийн Тухай хууль (2017)
12. Зөвшөөрлийн Тухай хууль (2022)
13. Төмөр Замын Тээврийн Тухай хууль (2024.01.01)
14. Төрийн Хяналт Шалгалтын Тухай Хууль (2003)
15. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар Хотын Эрх Зүйн Байдлын Тухай хууль (2021)
16. Соёлын Өвийг Хамгаалах Тухай хууль (2014)
17. Эрүүгийн Хууль (2015)
18. Хот Байгуулалтын Тухай (2008)
19. Усан Замын Тээврийн Тухай Хууль (2017)
20. Дотоодын Цэргийн Тухай (2017)
21. Органик Хүнсний Тухай (2016)
22. Авто тээврийн Тухай Хууль (1999)
23. Хог Хаягдлын Тухай Хууль (2017)
24. Засгийн Газрын Тусгай Сангийн Тухай Хууль (2019)
25. Ашигт Малтмалын Тухай Хууль (2006)
26. Орон Сууцны Тухай Хууль (1999)
27. Монгол Улсын Засгийн Газрын Тухай Хууль (1993)
28. Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж, Түүний Удирдлагын Тухай Хууль (2020)
29. Зөрчил Шалган Шийдвэрлэх Тухай Хууль (2017)

Бодлогын баримт бичиг, журам, зохицуулалт

- 1.Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010 он)

2. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (2016 он)
 3. Гамшгаас хамгаалах төрөөс баримтлах бодлого (2011 он)
 4. Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр (2011 он)
 5. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015)
 6. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2017 он)
 7. Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөр (2016 он)
 8. **Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 Оны Үйл Ажиллагааны Хөтөлбөр (2020 24 дугаар тогтоол)**
 9. **Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020 23 дугаар тогтоол)**
 10. **“Алсын Хараа-2050” Монгол Улсын Урт Хугацааны Хөгжлийн Бодлого (2020 52 дугаар тогтоол)**
 11. **“Шинэ Сэргэлтийн Бодлого”-Ыг Хэрэгжүүлэх Эхний Үе Шатны Үйл Ажиллагааны Хөтөлбөр (МУИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоол)**
- Цахим эх сурвалж**
1. <https://mongolia.gov.mn/>
 2. <https://www.parliament.mn/>
 3. <https://nema.gov.mn/>
 4. [Legalinfo.mn](https://legalinfo.mn)
 5. <https://www.gsmaf.gov.mn/gsmaf/commander>
 6. <https://uia.gov.mn/>
 7. <https://montsame.mn/>
 8. <https://mfa.gov.mn/>
 9. <https://www.nsc.gov.mn/>
 10. <https://www2.1212.mn/>